



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/335

Ховд


Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах, хэмжээ талбай өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Долдойн Долгор (ПЭ53030423)-ын эзэмшлийн Жаргалант сумын Наран баг Цагдаагийн газрын баруун хойд хэсэгт, музейн зүүн талд байрлах гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 132 метр квадрат газрыг кадастрын мэдээллийн сангийн зургийн дагуу 123 метр квадрат, хаягийг Галданбошигтын 1 дүгээр гудамжны 114 "ж" тоот болгон өөрчилж, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Магсаржав баг 6 дугаар гудамжны 16 тоотод байрлах Капитал банк (2556375)-ны үйлчилгээний зориулалттай 2453 метр квадрат газрыг Капитал ХХК-ийн эрх хүлээн авагч (2556375)-д, хаягийг Амарсанаагийн 1 дүгээр гудамжны 108 тоот болгон өөрчилж, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 15 жилийн хугацаагаар тус тус сунгасугай.

3. Газар эзэмших эрх нь сунгагдсан иргэдтэй гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн, гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Дөлбадрал)-т даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

8200 01 1508